



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-АДАРГА СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2026 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/07

Дуурлиг

Дотоод хяналтын баг байгуулж
журам батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн үйлчилгээний чанар хүртээмж, шуурхай байдал, албан хаагчдын ажлын бүтээмж, цаг ашиглалт, ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, эрсдлээс урьдчилан сэргийлэх, дотоод хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий багийг томилон ажиллуулж, бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2.Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулах, илтгэх, тайлагнах журмыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

3.Баталсан журмын дагуу дотоод хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах санал боловсруулж, тухай бүр байгууллагын удирдлагад танилцуулж ажиллахыг Дотоод хяналтын баг (Г.Үүрийнтуяа)-д даалгасугай


4.Дотоод хяналт шалгалт зохион байгуулах, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, эрсдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн ажлыг дэмжиж, ажиллах боломж бүрдүүлж байхыг нийт албан хаагчдад үүрэг болгосугай.



ДАРГА

С БАТ-ЭРДЭНЭ

Засаг даргын Тамгын газрын даргын 2026 оны
03 дугаар сарын 15-ны өдрийн 14 дугаар
тушаалын / дүгээр хавсралт




БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Багийн ахлагч: Г.Үүрийнтуяа Хууль,эрх зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Д.Дуламсүрэн Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн

Д.Өлзийсайхан Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан



ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ИЛТГЭХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ

Нэг: Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмын зорилго нь байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах, хууль тогтоомж, дүрэм журам, шийдвэрийн хэрэгжилтийг хангах, төрийн албан хаагчийн ажлын бүтээмж, цаг ашиглалт, төрийн үйлчилгээ, үйл ажиллагааны үр ашиг, сахилга хариуцлагыг дээшлүүлэхэд оршино.

1.2. Дотоод хяналт шалгалтыг Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан "Байгууллагад дотоод хяналт шалгалт зохион байгуулах нийтлэг журам"-д нийцүүлэн зохион байгуулна.

Хоёр: Дотоод хяналтын зорилго

2.1 Байгууллагын үйл ажиллагаа, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг хангах.

2.2. Төсвийн хөрөнгийн зарцуулалт, эд хөрөнгийн ашиглалт хамгаалалтыг сайжруулах.

2.3 Албан хаагчийн ажлын бүтээмж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх

2.4 Алдаа дутагдлыг олж тогтоох, ололтыг урамшуулах, санал санаачлагыг дэмжих

Гурав: Дотоод хяналтын чиглэл

- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт
- Төсвийн хөрөнгийн зарцуулалт, санхүүгийн сахилга бат
- Албан бичиг хөтлөлт, архив, бичиг хэргийн стандарт
- Хөдөлмөрийн дотоод журам, сахилга хариуцлага
- Иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар

Төрийн албан хаагчийн ажлын бүтээмж, цаг ашиглалт, ажлын төлөвлөгөө, гэрээний хэрэгжилт

Дөрөв: Хяналт шалгалтыг зохион байгуулах

4.1 Дотоод хяналтын баг нь тухайн жилд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж байгууллагын удирдлагаар батлуулан хэрэгжүүлнэ.

4.2 Шаардлагатай тохиолдолд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтыг зохион байгуулж болно.

Тав: Шалгалтын үр дүн